



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд дараах нэмэлт оруулсугай.

- 1.1. 9.2-т “...Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгоно.” гэсний дараа “Төлөөлөн удирдах зөвлөл гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүн байна.” гэж;
- 1.2. “9.17.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хараат бус гишүүдийг хууль, Засгийн газраас баталсан журмын дагуу сонгон шалгаруулж томилно.” гэж;
- 1.3. “9.18.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна” гэж;
- 1.4. “9.18.1.эдийн засаг, санхүү, бизнесийн удирдлага, инженер, хууль, эрх зүйн мэргэжилтэй, эсхүл тухайн компанийн салбараар мэргэшсэн байх” гэж;
- 1.5. “9.18.2.сүүлийн гурваас доошгүй жил тухайн компанийн толгой болон охин, хараат компанийн эрх бүхий албан тушаал болон зөвлөх, хүний нөөц, шагнал, урамшуулал хариуцсан ажилтнаар ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй, мөн өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ холбоогүй байх” гэж;
- 1.6. “9.18.3.тухайн компанийн толгой болон охин, хараат компанитай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд /зээлдүүлэгч, хувь нийлүүлэгчид, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран ажиллагсад г.м/-ын ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа холбоогүй байх” гэж;
- 1.7. “9.18.4.тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд, төрөл, садангийн холбоогүй байх” гэж;
- 1.8. “9.18.5.компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх. /Нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/” гэж;

- 1.9. “9.18.6.нэр дэвшигч өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлд бие дааж нэр дэвшүүлэх эрх олгохуйц хувьцааны багцыг эзэмшдэггүй байх.” гэж;
- 1.10. “9.19.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хуульд заасан шалгуурыг хангасан байхаас гадна эрх бүхий этгээдээс болон холбогдох журмаар тогтоосон ур чадвар, мэргэшил, боловсрол, ажлын туршлага зэрэг шаардлагыг хангасан байна.” гэж;

2. Дүрмийн 9.2-т “7 (долоо)” гэснийг “9 (ес)” гэж өөрчлөлт оруулсугай.

3. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Эрдэнэбулган)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ